

**ХУДАЛДАА ЭРХЭЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
..... ОНЫ-Р УЛИРЛЫН ТАЙЛАН**

I.Хаягийн хэсэг

1.Аж ахуйн нэгж, байгууллагын хаяг

Регистрийн дугаар							
	Нэр			Код			
Аймаг, нийслэл							
Сум, дүүрэг							
Аж ахуйн нэгж, байгууллагын нэр							

1. Аж ахуйн нэгжүүд **1, 4, 7, 10**-р сарын **21**-ны дотор дүүргийн статистикийн хэлтэс, сумын ЗДТГ-т маягтаар;
2. Дүүргийн статистикийн хэлтэс, сумын ЗДТГ-аас **1, 4, 7, 10**-р сарын **23**-нд нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтэст цахимаар;
3. Нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтэс **1, 4, 7, 10**-р сарын **25**-нд ҮСХ-нд цахимаар мэдээлнэ.

2. Холбоо барих хүний талаарх мэдээлэл

Овог, нэр	
Албан тушаал	
Утас	
Гар утас	
Факс	
Цахим шуудан	

3.Үйл ажиллагааны чиглэл

ЭЗҮАСА-4.0 код*

1. _____	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>
2. _____	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>
3. _____	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>
4. _____	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>
5. _____	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>

*Кодыг аймаг, дүүргийн статистикийн хэлтсийн мэргэжилтэн нөхнө.

II. Үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	МД	Хэмжих нэгж	Жилийн эхнээс өссөн дүнгээрх гүйцэтгэл	Улирлын гүйцэтгэл
				2
A	Б	В	1	2
1. Нийт орлого	1	мян.төг		
Бөөний худалдааны	2	мян.төг		
Жижиглэн худалдааны	3	мян.төг		
Засвар, үйлчилгээний болон бусад	4	мян.төг		
2. Борлуулсан барааны өртөг	5	мян.төг		
Бөөний худалдааны	6	мян.төг		
Жижиглэн худалдааны	7	мян.төг		
3. Ажиллагчдын тоо	8	тоо	X	
Эмэгтэй	9	тоо	X	
4. Худалдааны ашигтай талбайн нийт хэмжээ	10	м2	X	

Тамга

Захирал (эзэн)..... / /

Ерөнхий (ахлах) нягтлан бодогч / /

20.... онысарын

Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны улирлын тайлангийн маягт нөхөх заавар

Энэхүү маягтыг худалдаа эрхэлдэг, санхүүгийн тайлан тэнцэл гаргадаг, өмчийн бүх төрлийн статистикийн мэдээлэгчид тогтоосон хугацаанд үнэн зөв гаргаж мэдээлнэ.

"Статистикийн мэдээлэгч" гэж статистикийн мэдээлэл судалгаанд хамрагдсан, Монгол улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг, өмчийн бүх төрөлд хамаарагдах хуулийн этгээд, гадаадад үйл ажиллагаа явуулдаг Монгол Улсын хуулийн этгээд, Монгол Улсын болон гадаадын иргэн харьяалалгүй хүнийг ойлгоно.

ҮСХ нь ирүүлсэн мэдээг статистикийн үйл ажиллагаанд ашиглах бөгөөд мэдээллийн нууцыг Монгол Улсын "Хувь хүний нууцын тухай", "Байгууллагын нууцын тухай", "Статистикийн тухай" хуулийн дагуу чандлан хадгална.

Маягтад тусгагдсан байршил, ЭЗҮАСА-ын кодыг аймаг дүүргийн статистикийн хэлтсийн мэргэжилтэн нөхнө.

I. Хаягийн хэсэг

Аж ахуйн нэгжийн хаяг. Аж ахуйн нэгжийн нэр, регистрийн дугаарыг улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсанаар товчлохгүйгээр нөхнө. Аж ахуйн нэгжийн оршин байгаа аймаг, нийслэл, сум, дүүргийг нөхнө.

Холбоо барих хүний талаарх мэдээлэл. Энэ хэсэгт тухайн аж ахуйн нэгжийн дарга эсвэл нягтлан бодогчийн овог нэр, албан тушаал, суурин болон гар утасны дугаар, факс, цахим хаяг зэрэг үзүүлэлтүүдийг нөхнө.

Үйл ажиллагааны чиглэл. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэлийг нөхөхдөө эдийн засгийн үйл ажиллагааны стандарт ангиллын дагуу үйл ажиллагааны чиглэлийг дэлгэрэнгүй тодорхой бичнэ. Жишээ нь: компьютерийн сэлбэг хэрэгслийн жижиглэнгийн худалдаа, талх нарийн боовны жижиглэнгийн худалдаа гэж сайтар ялган бичнэ.

Үйл ажиллагааны чиглэлийн кодыг 4 оронгийн түвшинд "Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал" (ISIC-4.0) дагуу нөхнө.

II. Үндсэн үзүүлэлт

Нийт орлого. Аж ахуйн нэгжийн нийт орлогын дүнг тавих бөгөөд энэ нь бөөний болон жижиглэн худалдаанаас олсон орлого, засвар, үйлчилгээний болон бусад орлогын нийлбэртэй тэнцүү байна. Бөөний болон жижиглэн худалдааны холимог хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж борлуулалтын орлогыг бөөний болон жижиглэн худалдааны борлуулалтын орлого гэж салгаж тусгана. 1-р улирлын хувьд 1, 2-р баганад ижил дүн тавигдана.

Бөөний худалдаа гэж шинэ, хуучин барааг жижиглэнгийн худалдаачдад худалдах, түүнчлэн үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад худалдах, бөөний худалдаачдад эргүүлэн борлуулах, бөөний агентлаг хэлбэрээр хувь хүмүүс, компаниудаас бараа худалдан авах, эсвэл худалдах хэлбэрийн үйл ажиллагааг ойлгоно.

Жижиглэн худалдаа гэж хүн амын эцсийн хэрэглээнд зориулсан барааг дэлгүүр, лангуу, үүргийн худалдаа болон захиалга, дуудлагаар худалдах үйл ажиллагааг ойлгоно.

Засвар, үйлчилгээний болон бусад орлого гэж моторт тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээний болон үндсэн бус үйл ажиллагааны орлогыг ойлгоно.

Борлуулсан барааны өртөг гэж зөвхөн тухайн улиралд борлуулсан барааны худалдан авсан үнийн дүнг ойлгоно. Бөөний болон жижиглэн худалдааны холимог хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж борлуулсан барааны өртгийг бөөний болон жижиглэн худалдааны борлуулсан барааны өртгөөр салгаж тусгана.

Ажиллагчдын тоо. Тухайн тайлант хугацааны эцэст байгаа нийт ажиллагчдын тоог бичнэ. Үүнд удирдах ажилтан (захирал, эзэн, инженер зэрэг), ажилчид зэрэг тухайн байгууллагад ажилладаг бүх ажилтан орно.

Худалдааны ашигтай талбай гэж худалдааны үйл ажиллагаа явагдаж байгаа талбайн хэмжээг ойлгоно. Хэрэв дэлгүүр, захаар дамжин хийгддэггүй худалдаа эрхэлдэг бол 10-р мөрийг "0" гэж нөхнө.

Үндэсний статистикийн хороо

МЭЗСГ

Утас: 261565